

### ТЕЛЕВИЗИЙН ХӨГЖИЛ ХАНДЛАГА, МОНГОЛ-ХЯТАДЫН ТЕЛЕВИЗҮҮДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛД

С. Амартүвшин\*

\* Монгол улс, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургуулийн багш, доктор (Ph.D), дэд профессор

**Түлхүүр уг:** телевизийн хөгжил, хандлага, хамтын ажиллагаа, телевизийн өмчлөл, өмчийн хэлбэр, суваг

БНХАУ-ын болон Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбар дахь телевизийн салбар, түүний хөгжлийн ерөнхий дүр зургийг гаргахыг хичээн, мөн тус салбарт хоёр улс цаашид хамтран ажиллах нөхцөл боломж ямар байгаа талаар өөрийн саналыг тусгаж энэхүү өгүүллийг бичив.

#### Телевизийн салбарын хамтын ажиллагааны уламжлал

Монгол, Хятад хоёр орны сэтгүүлчдийн байгууллага, мэргэжил нэгтнүүд хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарч, байнга уулзарт форум зохион байгуулж, тодорхой чиглэлүүдээр хамтран ажиллаж ирлээ. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны бодлогын хүрээнд ч тодорхой зүйлийг тусгах болов. Үүний нотолгоо нь сүүлийн жилүүдэд Хятад, Монголын хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааны чиглэлээр зохион байгуулсан таван

удаагийн форум, тэдгээр форумын хүрээнд хийгдсэн ажлууд юм. Мөн энэ онд хоёр орон мөнхийн хөршийн найрсаг хамтын ажиллагааны дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ой тохиосон хийгээд БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад айлчилж, хоёр орны удирдагчид Монгол Улс, БНХАУ-ын хоорондын харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны түвшинд хүргэсэн цаашдын хамтын ажиллагааны гэрээний агуулгад ч манай хоёр орны сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн салбар дахь хамтын ажиллагаа улам бүр өргөжин хөгжих шинэ орчин бүрдээд байгааг юуны өмнө онцлон тэмдэглэх ёстай.

Ер нь хоёр орны телевизийн салбар дахь хамтын ажиллагааны уламжлалт харилцаа багагүй хугацаанд чамлахааргүй амжилттай хөгжиж ирсэн байх юм. Ийм харилцааны эхлэл хэзээ, хэрхэн тавигдсаныг тодорхойлохын өмнө хоёр улсын телевизийн салбарын хөгжлийг товч харьцуулан авч үзэх нь зүйд нийцэх учиртай.

Бидний хөрш БНХАУ 1958 онд телевиз хэмээх хүчирхэг хэрэгсэлтэй болж, анхны нэвтрүүлгээ цацны арав хүрэхгүй жилийн дараа манай Монголд

энэ хүчирхэг хэрэгслийг үүсгэн байгуулж, мөн л эхний нэвтрүүлгээ даруй ард түмэндээ үзүүлсэн тухтэй. БНХАУ-ын хувьд тухайн үеийн тэр засгийнх нь бодлого, удаа дараагийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд телевиз эрчимтэй хөгжих бололцоог бурдуулж, үүний үр дүнд телевизийн олон зуун станц, дахин дамжуулах станц үүсгэн байгуулагдаж, түүгээр ч зогсохгүй 1988 онд

тус улс сансарт

өөрийн хиймэл

дагуулаа хөөргөн, телевизийн хөтөлбөрүүдийг сансрын хиймэл дагуулаар цацах болсон эрчимтэй хөгжил салбарын түүхээс нь ажиглагддаг. Өнөөдөр шинэ зууны Хятад орны телевизүүдийн нийтлэл, нэвтрүүлгийн

бодлого, программын хэрэгжилтээс үзвэл арилжааны чиглэлээр хөгжих хандлагатай байна. Тодруулж хэлбэл БНХАУ-д явагдаж буй эдийн засгийн шинэтгэлтэй холбоотойгоор телевиз нь зар сурталчилгааны хэрэгсэл болох хандлага улам тод ажиглагдах болсон. Мөн энэ салбар дахь технологийн дэвшил асар эрчимтэй явагдаж байна.

Харин Монгол улсын тухайд 1990 онд шинэ нийгмийн тогтолцоонд шилжих, хэвлэл мэдээллийн эр чөлөөг хүлээн зөвшөөрөх болсноор хувийн телевизүүд үүсгэн байгуулагдаж эхэлсэн юм. Улмаар 1991 онд Монгол телевиз Ази, номхон далайн орнуудын телевизийн байгууллагад гишүүнээр элсэн, тэр жилээс нэвтрүүлгийг сансрын холбооны "Азиасат" системийн хиймэл дагуулын тусламж-

тайгаар орон даяар үздэг бол билээ. Эдүгээ аналоги системийг халх дэвшлийн замыг туулж байна. Тодруулбал Монголын телевизийн системд шилжих эхэлсэн бөгөөд 2014 оны 7-р сарын 31-нээс тоо он гэхэд бүх нийтээрээ тоон систем шилжих юм. Мөн дэлхийн жишиг хүрсэн технологийн дэвшлийг Мон

голдоо нэвтрүүлэх хандлага тус сар барт чухлаар төвигдах боллоо 2010-аад оноос манай зарим телевиз ("Монгол" телевиз) HD форматаар нэвтрүүлгээ цацаж эхэлж байсан бол өнөөдөр илүү тодрол, няярлтайгаар нэвтрүүлгээ үзүүлэх оролдлого өрсөл

дөөний нэг хэлбэр болж байна. Жишээ нь 2015 оноос зарим телевиз 4K ультра HD форматаар үзэгчидээ нэвтрүүлгээ бэлтгэн хүргэхээр одоогоор туршиж эхлээд байна.

Ийнхүү хөгжсөн хоёр орны телевизийн салбарын хөгжлийн явцад сэтгүүлчдийн байгууллага, телевизийн салбарынхан хамтран ажиллах баагай туршлага хуримтлуулсан нь мэдээ мэдээлэл солилцохоос эхлээд хамтран телевиз байгуулсан зэрэг хамтын ажиллагааны цөөнгүй ажлаас тодорхой харагддаг. Тодруулж хэлбэл МОНЦАМЭ болон СИНЬХУА агентлагаар дамжуулан мэдээлэл солилцож байсан бол хоёр орны БНХАУ, Монгол улсын радио, телевизүүдийн 1991 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу нэвтрүүлгийн программ солил-

цох, мэргэжилтэн ажиллуулж туршлага судлах, ӨМӨЗО-ны кино, телевиз, радиогийн өдрүүдийг Улаанбаатарт зохион байгуулах зэрэг ажил хийгдэж иржээ. Үүний нэг бодит жишээ бол 1996 онд БНХАУ-ын телевизийн бүтээл, "Баруун этгээдэд аялсан тэмдэглэл" уран сайхны олон ангит угзэрийн кино гарч эхэлсэн бөгөөд тухайн үед нийлүүлсэн хамгийн том контентүүдийн нэг байлаа.

1995 онд БНХАУ болон Монгол Улс хамтарсан хөрөнгө оруулалт хийж, "Сансар" кабелийн телевизийг Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод байгуулсан нь эдүгээ "Сансар медиа групп" болон өргөжкээ. Эдгээрийн зэрэгцээ Монголчууд бид Хятадын төв телевизийн нэвтрүүлгийг сансраас хүлээн авах зориулалтын антенн суурилуулан, ССТВ-ийн нэвтрүүлгийг кабелийн телевизээр үзэж байгаа билээ.

Хоёр орны сэтгүүлчдийн байгууллага, зарим телевиз, сургалтын байгууллагын санал санаачилга, идэвх оролцоогоор сэтгүүлчид харилцан туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх, телевизийн салбарын боловсон хүчин бэлтгэх, техник технологийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, контент нийлүүлэх, хамтран нэвтрүүлэг, уран бүтээл хийж бэлтгэх зэрэг зөвхөнгүй ажил амжуулсныг гэрчлэх баримт бий.

### Монгол орны телевизийн хөгжил, өнөөгийн байдал

Одоогоос 47 жилийн өмнө үүссэн Монголын телевиз өнөөдөр хөгжлийн хамгийн оргил цэгтээ хүрээд байна. Үүнийг төрөл бүрийн судалгаа, мэдээллийн хэрэгслийн ойрын 10 жилийн мониторгоос шинжлэн харж, тоон болон чанарын аль ч утгаар нь бусад мэдээллийн хэрэгсэлтэй харьцуулан

нотлох боломжтой. Тоон утгаараа гэхэд л өнгөрсөн онд Монгол тогтмол үйл ажиллагаа явуулсан 506 хэвлэл мэдээллийн хэрэгслийн 98 сэтгүүл, 123 сонин, 72 радио, мэдээллийн 71 вэб сайттай зэрэгцэн 142 телевиз тогтмол нэвтрүүлгээ дамжуулж байсан<sup>1</sup> статистик мэдээлэл батлан харуулж байна. Өмнөх оныхтой нь харьцуулахад л вэб сайт, телевиз хоёрын тоо есөөн бол бусад хэрэгслийн тоо буурсан байх жишээтэй. Ийнхүү сүүлийн үед Монгол оронд жил бүр телевизийн 10 гаран суваг тогтмол шинээр нэмэгдэж байна.

**X** эрэгсэл нь өсөхийн дээр хүлээн авах хэрэгсээ нь ч нэмэгдэж, телевиз үзэгчидийн тоо, хувь хэмжээ бусад уламжлалт мэдээллийн хэрэгслийн зэрэгцээ Монголчууд бид Хятадын төв телевизийн нэвтрүүлгийг сансраас хүлээн авах зориулалтын антенн суурилуулан, ССТВ-ийн нэвтрүүлгийг кабелийн телевизээр үзэж байгаа билээ.

Үндэсний хэмжээнд 16 телевиз нэвтрүүлгээ цацаж байгаа бол сүүлийн үеийн сансрын хиймэл дагуул ашиглан кабелийн сувгуудыг ч мөн бусад 30-аад сувгийг багцлан орон даяар дамжуулдаг боллоо. Эдгээр сувгийг хөрөнгө орны үзэгчид ч үзэх боломжтой болсон байна. Өнөөдөр телевиз ийнхүү бусад уламжлалт мэдээллийн хэрэгслийн дээсээ илүү хүчтэй болж, дижитал хувьсгалын эрин үед шинэ мэдээллийн хэрэгсэлтэй өрсөлдөн хэрэглэгчдээ татсаар байна.

Манай телевизүүд гадна дотны үзэгчидээ Интернет ашиглан цахим хувилбараар нэвтрүүлэг үзэх боломж нээж, тоон технологид шилжин нэвтрүүлгийг дуу, дүрсний өндөр чанартай (Full HD) цацах болсон. Мөн хөгжлийн түүхэнд "Интернет телевиз"-ийн эх

үндэс тавигдаж ([mglradio.com](http://mglradio.com)), ингэснээр хил хягааргүйгээр үзэгчдэд орчин үеийн телевизийн олон хувилбар бүхий сувгуудыг чөлөөтэй санал болгож байна.

Дээр дурдсан 142 телевизийг эрхлэн гаргагч, өмчийн хэлбэрээр нь ангилан үзвэл олон нийтийн телевиз, хувийн телевиз (үүний ихэнх нь арилжааны телевиз бол кабелийн телевиз ч оноор үйл ажиллагаагаа явуулсаар байна), өөр бусад орны хамтарсан телевиз ч бий болжээ. Гагцүү төрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэл байхыг хориглосон “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн шаардлагад нийцэн чөлөөтэй телевизийн өмчийн олон хэлбэр бий болсон.

**T**елевизийн ийм ёсөлт нь гагцүү чөлөөтэй хэвлэлийн өрсөлдөөний үр дүн юм. Ялангуяа 3 сая хүрэхгүй хүн амтай улс орны мэдээллийн зах зээлд зарим талаараа ахадсан үзэгдэл хэмээгдэн шүүмжлэлд өртдөг ч Монгол орны телевизийн хөгжил ийнхүү оргилдоо хүрчихээд байна. ХМХ төр засгийн мэдэлд байсан өмнөх тогтолцооны уед улсын гэгдэг ганц нэгэнх телевиз байсныг бодоход өнөөдөр тооны хувьд ч чанарын хувьд ч манай телевизүүд нийгмийн үргээ бүрэн дүүрэн биелүүлж чадаж байна. Энэ бол 1990 оны арчиллын үр дүнд хэвлэлийн эрх чөлөөтэй хөхиүүлэн дэмжих болж, ийм таатай нөхцөлд дэлхий нийтийг хамарсан тоон технологийн үсрэнгүй эрчимт хөгжил, дижитал хувьсгалын нөлөө Монголын телевизүүдийн хөгжилд онцгой таатай нөлөө үзүүлсэнтэй холбоотой.

Монгол улс “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуультай болсон 1998 оноос эхлэн өмнө нь улсын буюу төр засгийн мэдэлд байж, суртал ухуулгын

хүчирхэг хэрэгсэл болж байсан Монголийн Телевизийг олон шаардлага гарч, улмаар 2005 онд “Олон нийтийн радио, телевизийн тухай” хуультай болсноор энэ телевизийн зэмшил тодорхой болсон юм. Үүнээс хойш “олон нийтийн өмчийн хэмээгдэж, “Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз” гэгдэх болсон тус телевиз өнөөдөр хөёрдугаар сувгааг нээж, олон нийт болон цөөнхийн эрх ашигт үйлчилж, хэрэгцээт мэдээллийн түгээсээр байна.

Хувийн хэдхэн телевиз 1990-зэд оноос хөгжлийнхөө гарааг эхлүүлж байсантай харьцуулахад өнөөдөр арилжааны телевизуудийн ноёлох хандлага ажиглагдах боллоо. Мэдээллийн зах зээлийн өрсөлдөөнд телевиз хэмээх хүчирхэг хэрэгслийг хувь хүн, хувийн хэвшлийнхэн байгуулж мэдээллийн үйлдвэрлэлээр ашиг орлого олж болдгийг мэдрээд зогссонгүй бусад төрлийн мэдээллийн хэрэгслүүдийг дэргээд үүсгэж, улмаар медиа групп байгуулагдаж, телевизийн систем улам бүр хүчирхэгжсээр байна. Ингэж Монголын сэтгүүл зүйн хөгжилд дэлхийн жишгээр хэвлэл мэдээллийн төвлөрөл хэмээх үзэгдэл хандлагыг хамгийн ихээр бий болгож байгаа хэрэгсэл бол телевиз юм. Мэдээж улс төр, бизнесийн ашиг сонирхол их, бага хэмжээгээр байгаа ч телевизийн хөгжлийг хөндлөнгөөс нь ажиглахад энэхүү нөлөө бүхий хүчирхэг хэрэгслийн орон зайд Монголд улам бүр тэлсээр байна. Үүний нэг нотолгоо бол Монголын телевизуудийн эрчимтэй хөгжлийг дагаад мэдээллийн энэхүү зах зээлд гадны хөрөнгө оруулалт ихээр орж ирэх, хамтарсан телевизийн сувгууд оноор нээгдэх хандлагатай болсон явдал юм. Жишээ нь бидний сайн

мэдэх Оросын хөрөнгө оруулалттай “Аист” ТВ, БНХАУ-ын хамтарсан хөрөнгө оруулалттай “Сансар” медиа групп, Олон улсын “Блуумбэрт” телевизийн Монгол дахь суваг газ мэт.

**E**р нь Монголын телевизийн салбар өнөөдөр хөрөнгө оруулах, бизнес эрхлэх том талбар болсныг энд цохон тэмдэглэмээр байна. Ялангуяа телевизийн контент нийлүүлэхээс эхлээд техник, технологи нэвтрүүлэх, оруулж ирэх, хамtran бизнес эрхлэх хөрөнгө оруулалтын таатай орчин юм. Одоо гагцүү манай телевизүүд хүрээгээ тэлж, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай болж, ирээдүйн томоохон олон улсын шинжтэй төл сувгуудыг үүсгэхэд урд хөршийн телевизийн салбартай илүү шаргуу хамtran ажиллах л үлдээд байна.

### Цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж

Дээр дурдсан хоёр орны төрийн тэргүүний байгуулсан иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээнд тусгагдсан төслийн хүрээнд хэвлэл мэдээллийн салбарт хамtran ажиллах чиглэлээр илүү үр дүнтэй, хоёр орны телевизуудийн хамтын ажиллагааг өргөжүүлсэн алхмуудыг хийх боломж бурдаж. БНХАУ-ын дарга Си Зиньпин “ирэх таван жилийн туршид Хятадын талаас Монголын талд 1000 сургалтын квот олгоно. Мөн Засгийн газрын тэтгэлгийн квот 1000-ыг шинээр олгоно. Монголын 500 цэргийн албан хаагчийг сургана. Монголын 500 запуус, 250 сэтгүүлчийг Хятадад айлчлуулна. Монголын талд Хятадын шилдэг 25 кино, телевизийн нэвтрүүлгийг үнэ төлбөргүйгээр өгнө”

гэснийг энд жишээ болгон дурдах хэрэгтэй.

Ингээд хоёр орны телевизийн салбарын хамтын ажиллагаанд нэмэр болох дараах хэдэн саналыг дор өгүүль.

1. Хоёр орны ард түмний харилцааг бэхжүүлж, зарим үл ойлголцлыг арилгах чиглэлээр телевизүүд хамtran ажиллаж, хоёр улсын үндэстэн угсаатны соёл, сэтгэлгээг зөвөөр ойлон ухаарах нийтлэл нэвтрүүлгийн кампаанит ажлыг санаачлах шаардлагатай болжээ гэдэг нь сая болсон БНХАУ-ын дарга Си Зиньпиний аялчлалын уезр тодорхой харгадлаа. Телевиз бол соёлыг түгээч нэг хүчирхэг хэрэгсэл билээ.

2. Хоёр орны сэтгүүлчийн байгууллагын санал санаачилгын зэрэгцээ өнөөдөр Монгол дахь телевизийн мэдээллийн зах зээлийт хөрөнгө оруулалт, хамтын гэрээгээр илүү үр шимтэй бизнес болгох тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй байна. Товчдоо бол Монгол улсын мэдээллийн үйлдвэрлэлийн өрсөлдөөний талбарт шударга өрсөлдөхөд гадна дотны телевизүүдэд үүд хаалга нээлттэй болсон. Мөн Монголын телевизуудийн өрсөлдөөний зах зээлийг урд хөрш рүү хандуулах боломжийг хайх шаардлагатай байна.

3. Сэтгүүлчийг харилцан солилцож туршлага судлах, сургах чиглэл ч чухал хэвээр байна. Ялангуяа шинэ техник технологийн дэвшилгийг судлах, нэвтрүүлэх чиглэлд анхаарууштai.

4. Монгол улс БНХАУ-ын зах зээлээс телевизор импортлогч орны нэг билээ. Сүүлийн үеийн судалгаагаар телевизор, түүний дамжуулах болон дагалдах хэрэгслийд, телевизийн мэргэжлийн тоног төхөөрөмж нийлүүлэн, оруулж ирэх нь улам бүр өссөн байна.

## Ишлэл

Энэ зах зээлийг телевизийн мэдээллийн үйлдвэрлэлийн бизнестэй холбож, үйлдвэрлэлийг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажил санаачлах нь чухал юм.

5. Мэргэжлийн байгууллагууд хамтран телевизийн уран бүтээлийн уралдаан шалгаруулалтыг санаачлан, хамтарсан бүтээлийн эрэл хайгуул, хоёр орны харилцаанд чухал үүрэг гүйцэтгэх контент үйлдвэрлэх, бүтээл гаргах чиглэлийг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд хоёр орны сэтгүүл зүйн салбарын харилцаа, хамтын ажиллагааны гол талбар нь телевизийн салбар болоод байна. Иймээс хөрш орны харилцаа болон хэвлэл мэдээллийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд үүсч буй таатай нөхцөл байдал, бодит боломж зэргийг ашиглан телевизийн салбарт түлхүү анхаарч, мэдээллийн зах зээлээ тэлэх тодорхой бодлого барих цаг нэгэнт болсон байна.

<sup>1</sup> Хэвлэлийн хүрээлэнгээс хийсэн "Хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиглалтын байдал" судалгааны дүнгээс.

<sup>2</sup> Мөн тэнд.

## Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.
2. Зулькафиль М., Чойсамба Ч. 2005. Сэтгүүл зүйн түүх. УБ.
3. Норовсурэн Л. 2002. Монголын сэтгүүл зүйн түүх. Гутгаар дэвтэр. УБ.
4. 1997. Зурагт зулын хойморт. УБ.
5. Хэвлэл мэдээллэл өнөөдөр (мониторингийн цуврал). УБ. 1999-2013 онууд.

## Summary

This article is about tendency and development of modern television on example Mongolian-Chinese television. They aren't similar in social, economical development, technological progress but there is a research way to comparative study about how is their television's development as a media. We have tried to compare the media's development using as an example two countries.